

ЁС ЗҮЙ

“Таалагддаг гахай байснаас таалагддаггүй хүн байсан нь дээр, таалагддаг тэнэг байснаас таалагддаггүй Сократ байсан нь дээр, яагаад гэвэл гахай болон тэнэгүүд зөвхөн өөрсдийгөө л боддог. Харин бусад хүмүүс харьцуулахын тулд өөрсдийгөө ч, бусдыг ч аль алиныг нь ойлгодог”. Жон Стюарт Милль

Хүмүүс ёс зүйн талаар буруу ойлголттой байдаг. Ёс зүй нь хүмүүсийг цээрлүүлэн шийтгэх, хянан дарамтлах, буруушаан яллахын тулд байдаггүй юм. Харин шүүх, цагдаа болон шорон зэрэг нь ёс зүйн төлөөнөө буй болдог ч ёс суртахууныг үнэнхүү баримталдаг гэж хэн ч хэлэхгүй байх. Сократ шоронд үхсэн ч өөрийг нь шүүсэн шүүгчээс илүү эрх чөлөөтэй байж. Магадгүй эндээс л философи эхлэх болов уу. Ёс зүй эндээс, бид бүхнээс ямагт эхэлдэг. Ямар ч торгууль, ял оноох шаардлагагүй шийтгэл үр нөлөөгүй байдаг, эцэст нь гадны зэмлэл шаардлагагүй тэр цэгээс л ёс зүй эхэлдэг. Ёс зүйн асуудал биднийг эрх чөлөөтэй байхад л үүсдэг. Энэ бол эрх чөлөө буй болж, өөрийгөө хянаж байна гэсэн үг.

Дэлгүүрт та нэг CD юм уу, эсвэл нэг хүрэм хараад хулгайлмаар бодогдож л дээ... Гэтэл дэлгүүрийн хянагч таныг хараад зогсож байвал, эсвэл дэлгүүрт хянах дуран байрлуулсан байвал баригдаж шийтгүүлэх, зэмлүүлж буруушаагдахаас магадгүй та айх байх... Энэ бол үнэнч шударга байдал биш, энэ бол хувийн ашиг сонирхол. Энэ бол ёс зүй биш, харин энэ бол болгоомжлол. Цагдаагаас эмээх нь сайн чанар гэхээсээ зүгээр л хаширлал.

Та өөрийгөө Платоны бичсэн “Гайжэс”-ийн алдарт бөгжтэй гээд төсөөл дөө. Энэ бөгж нь нэгэн хоньчны олсон, хүсвэл таныг харагдахгүй болгодог шидэт бөгж юм. Бөгжний шигтгээг гарынхаа алга руу харуулбал хоньчин үл үзэгдэгч болж, харин түүнийг буцааж эргүүлбэл тэр харагдах болно. Тухайн цаг мөчийг хүртэл үнэнч нэгэн байсан хоньчин Гайжэс бөгжний ид шидийг ашиглан тэвчиж чадалгүй ордонд орж, хатныг ятган хааныг хөнөөгөөд өөрөө хаан ширээнд сууж хэмжээлшгүй эрх дархыг эдэлдэг... Платоны бичсэн “Төр улс”-д эл байдлыг хүүрнэгч нь муу хүнээс сайн хүнийг, сайн юм шиг харагдах хүнээс муу юм шиг харагдах хүнийг яаж ялгадгийг, эсвэл дүр эсгэгчдээс зүгээр нэг болгоомжтой хүн юугаар ялгаатайг дүгнэн харуулсан юм. Өөрөөр хэлбэл энэ нь “сайн хүн” гэсэн ядмаг ойлголтыг бусдын санаанд буй болгох буюу хорон муу санаагаа нуун далдлахуй юм.

... Хэрэв сайн болон хорон муу санаатай хүн хоёулаа Гайжэсийн бөгжтэй байсан бол тэдний хооронд ямар ч ялгаа байхгүй байхсан. “Хоёулаа л адилхан зүйлийг хийнэ”. Энэ нь ёс зүй гэдэг бол зүгээр л хий хоосон, худал зүйл, ариун журмаар өнгөлөгдсөн аймшиг юм гэдгийг хэлж өгч байна. Энэ нь бид өөрсдийгөө үзэгдэхгүй болгох хүч шидтэй байсан бол бүх хорио цээр үгүй болж, хүн бүр өөрсдийнхөө тааллаар хүссэн болгоноо хийнэ гэдгийг хэлж өгч байна.

Энэ үнэн гэж үү? Мэдээж Платон үүнийг үнэн гэж бодоогүй. Гэхдээ та платонч байх албагүй шүү дээ... Цорын ганц үнэн хариулт таньтай л холбоотой учраас зөвхөн танд байгаа. Та ид шидтэй бөгжтэй гээд төсөөл дөө. Та юу хийх байсан бэ? Та юуг хийхгүй байсан бэ? Та бусдын өмчийг, тухайлбал бусдын хувийн эрх, бусдын нууц, бусдын эрх чөлөө, бусдын нэр хүнд, бусдын амьдралыг хүндэтгэсэн хэвээр байж чадах уу? Хэн ч танд хариулт өгч чадахгүй. Асуудлын гол нь зөвхөн та л байгаа юм. Та үл үзэгдэгч боллоо гэхэд одоо хийдэггүй зүйлээ хийхийг өөртөө зөвшөөрөх аваас энэ нь таныг болгоомжлол, эсвэл дүр эсгэхэд түлхэхээс бус ёс зүйд төдийлөн хүргэхгүй байх. Өөрийгөө хориглох, өөрийгөө шаардах нь та үл үзэгдэгч болсон ч таны хувийн ашиг сонирхолоос бус, харин үүрэг хариуцлагаас урган гарах нь гагцхүү шууд ёс зүй юм. Таны сэтгэл өөрийн гэсэн шалгууртай. Таны ёс суртахуун бас өөрийн гэсэн шалгууртай

ба та түүгээр өөрийгөө шүүдэг. Таны ёс суртахуун бол бусад хүмүүс юу гэж бодох хийгээд гадны ямар нэгэн сүрдүүлгээс бус, харин сайн болон муу, үүрэг хариуцлага болон хориг цээр, тэрчлэн юу зөвшөөрөгддөг хийгээд юу зөвшөөрөгддөггүй болох, та болон хүн төрөлхтөн гэсэн тусгаар ойлголтууд дээр үндэслэн юу шаардаж байгаагаас чинь урган гарна. Практик дээр ёс суртахуун бол та дийлдэшгүй үл үзэгдэгч байсан ч гэсэн таны баримталдаг зарчмуудын цогц болно.

Энэ нь хэтэрхий их зүйл үү, эсвэл бага зүйл үү? Энэ бол таны шийдэх асуудал. Хэрэв та үл үзэгдэгч байсан бол гэм зэмгүй хүнийг шийтгэх үү? Жишээ нь найзаасаа урвах, хүүхэд зодох, хүчин болон яргалал үйлдэх, хүний амь хороох зэргийг хийх үү? Эдгээрт та л хариулж чадна. Таны ёс зүй таны хариултаас бүрэн хамаарна. Танд бөгж байхгүй байсан ч гэсэн таны бодох, шийдэх, үйлдэхэд энэ нь саад болохгүй. Үнэнч болон муу хүмүүст гадаад байдлаар халхлагдсан ялгаа байдаг бол энэ нь үнэнч хүмүүсийн хувьд бусад хүмүүс юу гэж бодох нь хамаагүй, болгоомжлол тэдэнд хэрэггүй байдагт оршино. Энэ нь ёс зүйн хувьд аз туршилт бөгөөд туйлын зожигрол юм.

Ерөөсөө ёс зүй биднийг өөр бусадтай, бас биднийг өөрсөдтэй маань холбодог юм. Ёс зүйтэй байх гэдэг нь мэдээж бусдын ашиг сонирхлыг бодож үзэх явдал боловч Платоны үзсэнчлэн “бурхан тэнгэрийн ч бай, хүний ч бай хяналтаас гадуур”, өөрөөр хэлбэл ямар нэгэн шагнал горьдолгүйгээр, эсвэл шийтгэл хүлээлгүйгээр өөрийнхөө үйлдэлд өөрөө гэрч нь болох юм. Энэ нь аз туршсан явдал уу? Би санаагаа тодорхой илэрхийлээгүй байж болох учраас дахин давтаж хэлэхэд энэ нь зөвхөн танаас л шалтгаална. Энэ бол аз туршилт биш, харин сонголт. Юу хийх ёстойг зөвхөн та л мэднэ, хэн ч таны өмнөөс шийдэж чадахгүй. Ёс зүйн онцлог болон хүч чадал нь та сайн гэж үзсэн зүйлээ хийх, муу гэж үзсэнээсээ татгалзах, эдгээрийн төлөө ямар нэгэн шагнал горьдолгүй, сайн зүйл хийсэн бол түүнийг нь хэн ч мэдээгүй ч түүнээсээ сэтгэлийн таашаал олж авахад оршино.

“Сайн үйл баяр баясгаланг буй болгодог” хэмээн үүний шалтгааныг Спиноза тайлбарлажээ. Энэ бол өөрөө шалтгаан юм. Та өөрийгөө хүндлэхгүй юм бол яаж аз жаргалтай байх юм бэ? Өөрийгөө та хянаж, удирдаж, дутагдлаа ялан дийлэхгүй юм бол яаж өөрийгөө хүндлэх юм бэ? Бөмбөг хэдийгээр таны талбайд байгаа ч тоглолт хүртэл тоглоом биш гэж ярьцгаадаг. Яг энд, яг одоо та юу хийдэг нь та өөрөө юм. Энэ бол таны амьдрал. Ёс суртахууны хувьд өөр хэн нэгэн болохсон гэж мөрөөдөх нь учир утгагүй юм. Та баян, эрүүл бөгөөд сайхан харагдаж, аз жаргалтай байхыг мөрөөдөх нь учир утгагүй. Сайн, эсвэл муу хүн алин байх нь таны шийдэх асуудал, таны үнэ цэнэ яг юуг хүсэж байгаагаар тань хэмжигдэнэ.

Ёс зүй гэж юу вэ? Энэ бол өөрийг хувиараа шахах, өөрөөсөө татгалзах, давын өмнө хувиа хичээхээс өөр юу ч үгүй, өөрийн сайн сайхан халамж, аз жаргалыг эрхэмлэлгүй, харин өөдгүй амьтан байхаас татгалзаж, өөрийн болон хүн төрөлхтний зайлшгүй үзэл санаанд үнэнийг үлдээх зорилгоор бусдын ашиг сонирхол, эрхийг анхаарч ойлгох зэрэг зүйлүүдийн цогц нийлбэр гэж үзвэл зохилтой.

Ёс зүй бол “Би юу хийх ёстой вэ?” гэдэг асуултын хариулт болно. Энэ бол миний үүргүүдийн, өөрөөр хэлбэл үеийн үед бусдын адил зөрчиж байдаг хэрнээ хууль ёсны хэмээн миний итгэж ирсэн захирамжуудын цогц юм. Энэ бол бусдын санаа бодлоос хамааралгүй, алив шагнал урамшуулал болоод шийтгэл зэмлэл хүлээхгүй, би өөртөө оноосон, эсвэл оноох ёстой хууль юм.

“Би юу хийх ёстой вэ”, юуг хийх ёсгүй вэ?, “Бусад хүмүүс юу хийх ёстой вэ?”. Эдгээр нь ёс зүйг сургамжлалаас ялгаж байгаа юм. Алайныхаар бол “ёс зүй нь хэзээ ч хэн нэгэн хөршийнх байдаггүй”, хөршийнхөө үүрэг хариуцлагад санаа тавьсан хэн ч бай ёс суртахуунч биш, харин сургамжлагч болно. Үүнээс илүү утгагүй зорилго, тааламжгүй хүний талаар төсөөлөх боломжтой гэж үү? Ёс зүй бол зөвхөн ангид ганц хүнд л хууль ёсны зүйл. Хэн нэгэнд “Чи өгөөмөр байх хэрэгтэй” гэж хэлснээрээ өгөөмөр сэтгэл гаргаж байгаа бус, “чи зоригтой байх ёстой” гэж хэлэх нь зоригтой байгаагийн баримт бус. Ёс зүй зөвхөн танд л үйлчилнэ. Үүрэг зөвхөн тухайн хүнд л хэрэглэгдэнэ. Харин бусдын хувьд өрөвч сэтгэл, хууль хоёр хангалттай.

Үүнээс гадна хэн бусдын санаа зориг, түүний шалтгаан, гавъяа зүтгэлийг мэдэж чадах вэ? Хэрэв бурхан тэнгэр байдаг бол түүнээс өөр хэн ч ёс суртахууныг шүүж чадахгүй, өөрийнхөө ёс суртахууныг өөрөө шүүх нь хангалттай. Та хувиа хичээж байсан уу? Та хулчийж байсан уу? Та хэн нэгний сул дорой тал, сэтгэлээр унасан болон гэнэн байдлыг ашиглаж байсан уу? Та худал хэлж, хулгай хийж, хүний амь хороож байсан уу? Та энэ бүгдийг сайн мэдэх ба энэхүү өөрийн мэдлэгийг бид ухамсар гэж нэрлэдэг юм. Ёс зүйн үүднээс аваад үзвэл энэ нь цорын ганц шүүгч юм. Шүүх хурал? Торгууль? Хорих ял? Энэ бүгд бол хүмүүсийн буй болгосон бэлгэдлийн чанартай юмс болохоос цагдаа болон хуульчдынх биш. Хэдэн ялтан гадуур чөлөөтэй алхаж байна вэ? Хэдэн үнэнч шударга хүн шоронд хоригдож байна вэ? Та магадгүй нийгмийн хуулиудад өөрийгөө зохицуулж нийцүүлэх байх л даа, эргэлзэх хэрэггүй. Гэхдээ таны ганц үнэн хууль болох ухамсар болон өөрөөсөө чөлөөлөгдөж чадахгүй.

Тэгэхлээр хувь хүмүүсийн тоогоор төдий чинээ ёс зүй байна гэсэн үг үү? Огт үгүй. Энэ бол ёс зүйн парадокс. Энэ нь анхны ганц хүнд зөвхөн хамаатай бөгөөд бас түгээмэл холбогдолтой, өөрөөр хэлбэл хүн бүрт хамааралтай (хүн бүр “би” байдаг). Амьдрал дээр ёс зүй нь хүмүүсийн боловсрол, тэдний амьдран буй нийгэм, эрин үе, эргэлдэн буй орчил, өөрийн гэсэн соёлоос хамааран ялгаатай байж болно... гэдгийг бид мэддэг. Туйлын ёс зүй гэж байхгүй, түүнийг бүрэн мэддэг хүн гэж үгүй. Харгислал, арьс өнгөөр ялгаварлах хийгээд хүний амийг хөнөөхийг цээрлэх нь хувь хүний үзэл бодлоос хамаарах амар бус асуудал юм. Энэ нь үндсэндээ нийгмийн, өөрөөр хэлбэл бүхэлдээ хүн төрөлхтөн болоод иргэншлийн эсэн мэнд үлдэх хийгээд нэр төрийн асуудал юм.

Хэрэв хүн болгон худлаа ярьдаг байсан бол цаашдаа хэн ч хэнд ч итгэхээ больж, үнэндээ худал хэлэх зүйл ч олдохгүй болох байсан. Худлаа хэлэх нь урд өмнөх итгэлийг эвдэж, бүх харилцаа дэмий хоосон, утгагүй, үр дүнгүй болох байсан.

Хэрэв хүн болгон хулгай хийдэг байсан бол нийгмийн амьдрал боломжгүй бөгөөд өөдгүй муухай, эвгүй олиггүй болох байсан. Өмчлөх ойлголт байхгүй болж, хулгайлах зүйл ч үлдэхгүй байх байсан.

Хэрэв хүн болгон хүний амийг хөнөөдөг байсан бол хүн төрөлхтөн, иргэншил сүйрэн мөхөх байсан. Хүчирхийлэл болон айдсаас өөр юу ч үлдэхгүй болж, бид бүгдээрээ өөр өөрсдийнхөө хохирогчид, эсвэл алуурчид болох байсан ...

Эд бүгд нь зөвхөн таамаг төсөөлөл хэдий ч ёс зүй гэж юу вэ гэдэг асуулт уруу биднийг хөтөлж байгаа юм. Та ямар үйлдлийг ариун, эсвэл зэмлүүштэй алин болохыг мэдэхийг хүсэж байгаа биз дээ? Хэрэв хүн болгон тань шиг авирлавал амьдрал ямар болох вэ гэдгийг өөрөөсөө асуугаад үз дээ. Хүүхдийг зажилсан бохио гудамжинд хаявал эцэг, эх нь “Хэрэв хүн бүр чам шиг ингээд байвал хаа сайгүй хог болж, чамд ч, бусад хэн бүхэнд тааламжгүй болох бус уу?!” гэж хэлдэг. Бүр туйлшруулаад хүн болгон худлаа ярьж, хүн алж, хулгай хийж, хүчирхийлэл үйлдэж, халдлага дайралт хийж, тамлаж яргалдаг гэж төсөөлөөд үзье л дээ... Ийм ертөнцийг хэн хүсэх юм бэ? Яаж тийм юмыг хүүхдүүддээ тохиолдоосой гэж та бодох юм бэ? Өөрийнхөө хүсэж буй юмнаас яаж та ангижирах юм бэ? Тэгэхлээр та бусдыг яллах тийм зүйлийг цээрлэж, итгэл болгосон зүйлээ тэвчих ёстой. Энэ бол маш чухал асуудал. Ёс суртахуунлаг байна гэдэг нь бидний итгэж, хүсэж байгаа, холбогдох ёстой хуулиа бид өөрсдөө даган мөрдөх явдал юм. Энэ нь “Act only on that maxim by which you can at the same time will that it should become a universal law” гэж Кантын “Ёс суртахууны метафизикийн үндсүүд”-дээ илэрхийлсэн эрс императивийн тухай алдартай илэрхийллийн гол утга санаа болно. Энэ бол “мөхөс, хөгшин минийхээс” илүү хүн төрөлхтний үйлддэгээр хийх, хэн нэгний хүсэл, ашиг сонирголоос илүү бусдын ухаан бодлыг дагна гэсэн үг. Хэрэв тулгуурлан байгаа зарчим нь амьдрал дээр бүхэнд хэрэглэгдэж байвал үйлдэл зөв байх болно. Ёс суртахуунлаг үйлдэх гэдэг нь хүн бүр адил зарчмыг баримталж үйлдэх тийм аргаар үйлдэхийг хэлнэ. Энэ нь Евангелийн санаатай (бусад шашинд ч иймэрхүү үзэл бас олдоно), хүн төрөлхтөний оюун санаатай, “Бусдыг байлдан олж авахын тулд өөртөө ханддаг болтол тэдэнд ханд” гэж Руссогийн хэлсэн бишрэм үгтэй үнэхээр нийцэж байгаа юм. Бас энэ нь “төгс төгөлдөр бус ч магадгүй өмнөхөөс илүү хэрэгтэй, бусдад аль болохуйц бага хор хүргэж, өөртөө сайн зүйлийг хий” гэж хэдийгээр арай даруухан,

маргаангүй томъёолсон Руссогийн энэрэнгүй санаатай нийцэж байна. Энэ нь эцэстээ өөрийн төлөө гэхээсээ илүү, бусдын төлөө амьдрах, гэхдээ өөрийн оюун санаа, бодол санаагаараа амьдрах гэсэн үг юм... Алайн "ганцаараа аливааг..." гэж хэлжээ. Ёс зүй гэдэг бол энэ л юм.

Энэ ёс зүйг зөвтгөх үндэслэл бидэнд хэрэгтэй юу? Энэ бол шаардлагагүй, боломжгүй ч байж магадгүй. Хүүхэд усанд живж байвал түүнийг аврах болсон шийдвэрээ зөвтгөх хэрэгтэй юу? Харгис этгээд бусдыг хөнөөж, дарамталж, тамлан тарчлааж байвал түүнийг эсэргүүцэж байгаагаа та зөвтгөх хэрэгтэй юу? Ийм үндэслэл нь бидний үнэлэмжийн үнэ цэнийг баталгаажуулах маргаангүй үнэн болж чадна. Энэ нь биднээс өөр үнэлэмжтэй хүнд ч бид зөв, та буруу гэдгийг батлах боломжтой. Гэхдээ түүнийг хийхийн тулд шалтгааныг нь үндэслэх хэрэгтэй ба бид түүнийг хийж чадахгүй юм. Априор зарчим байхгүй, аливаа өөрчлөлтөнд шалгагдсан ямар баталгаа байж болох вэ? Үнэнхүү ёс суртахууныг нотлох ямар үндэслэл байж болох вэ? Бид амиа хичээсэн үзлийг өгөөмөр байдлын дээр, худал хэлэхийг үнэнч шудрагын дээр, хүчирхийлэл, хэрцгий балмад явдлыг дөлгөөн, өрөвч сэтгэлийн дээр тавьдаг хүнийг чи буруу гэж яаж батлах юм вэ? Хэрэв бид чадсан ч энэ нь ямар утгатай болох вэ? Зөвхөн өөрийгөө боддог хүн учрыг яагаад бодох гэж? Зөвхөн өөрийнхөө төлөө амьдардаг хүн нийтлэг зарчмын талаар яагаад санаа зовох билээ? Бусдын эрх чөлөө, нэр сүр, амьдралыг гутаан хөсөрдүүлдэг этгээд яагаад үл зөрчилдөх зарчимд хумсын чинээ ч анхаарал хандуулна гэж? Хэрэв бид түүнтэй тэмцвэл түүнийг няцаах нотолгоо яагаад хэрэгтэй гэж? Зөвүүцэл, эгдүүцэл няцаагддаггүй юм. Нүгэл, хор хөнөөл няцаагддаггүй юм. Бидэнд хүчирхийлэл, хэрцгий балмад хийгээд зэрлэг явдлын эсрэг тулаанд ёс зүйн үндэслэгээнээс илүү зориг зүрх хэрэгтэй. Бидний үйл ажиллагаанд ёс зүйн үндэслэгээнээс илүү өөрсдийнхөө төлөөнөө сахилга бат, үнэнч шударга зан байдлыг бид эрхэмлэх хэрэгтэй. Юу хамгийн чухал вэ гэвэл хүн төрөлхтөн өөртөө бүтээсэн зүйлийг бид хүндэтгэнэ гэдгээ батлах явдал. Яагаад бид түүнийг үндэслэж, бас хамгаалах ёстой гэж? Яаж эдгээр зүйлс боломжтой болох вэ? Сэтгэл ханамжтай болох уу, хэрэгтэй зүйл мөн үү?

Алайн "Ёс зүй нь оюун санааны нэг илрэл бөгөөд эрх мэдэл, нөлөө бүхий хэн нэг нь нийгмийн байр сууриа ашиглан бусад хүмүүст туслах ёстой гэсэн үзэл санаа юм. Ёс суртахуунд хэн нэгэн өөрийн нэр төрөө мэдрэхээс илүү юм үгүй" гэж бичжээ. Ёс зүй нь хүмүүс өөрийн болоод бусдын хүмүүнлэг сэтгэлийг хүндэтгэх явдал юм. Энэ нь өөрөөсөө татгалзаж, өөрийгөө няцааж, чармайж, тэмцэхгүйгээр буй болохгүй. Энэ талаар бодохгүй байгаа, эсвэл зөвхөн өөрийгөө боддог зангаасаа таныг татгалзахыг шаарддаг, өөрийн уур хилэн, хувиа бодох үзэл, тааламжгүй байдлаас татгалзах, эцэст нь тэдгээрийг дарж авахыг танаас шаарддаг. Энэ нь эрэгтэй болон эмэгтэй хүн байх, нэр төртэй чухаг хүн байхын тулд мэрийхийг танаас шаарддаг.

"Хэрэв бурхан тэнгэр оршин байдаггүй юм бол юм бүхэн зөвшөөрөгдөнө" гэж Достоевскийн зохиолын нэгэн баатар хэлдэг. Гэвч энэ бол үнэн биш, бурхан тэнгэрт итгэх, эсэх нь хамаагүй та өөртөө бүх юмыг зөвшөөрдөггүй. Бүх юм гэдэгт хамгийн өөдгүй юм, танд зохихгүй юм ч багтаж байгаа!

Ёс зүйг эрхэмлэгч нь зөвхөн там, диваажин гэж байдаг гэсэн итгэлээсээ болоод буянтан болдоггүй. Зүгээр л хувиа хичээсэн юм уу, эсвэл хэрсүү хүн байж болно. Кантсн хэлснээр сайн үйлс бүтээдэг хүн л зөвхөн аврагдаж мэднэ, харин муу юм хийдэг хүн аврагдахгүй. Энэ бол ёс зүйн үүднээс үйлдэл нь Кантын хэлснээр зөвхөн "тухайн үйлдлийн үр дүнгээс" хамаарахгүй нөхцөлд л сайн гэсэн үг. Бид тэгэхлээр модернизм, эсвэл секуларизм дээр ирсэн байна. Энэ бол францын соён гэгээрүүлэгч философичдын үзэл санаа юм. Бейл, Вольтер бас Кантын үзэл санаа юм. Шашин ёс зүйн үндэс биш, харин ёс зүй шашныг засаж, үндэслэлээр хангаж байдаг. Бурхан тэнгэр гэж байдаг учраас би сайн үйлсийг хийх ёстой биш. Ач буяныг мэдрэхийн тулд биш, харин цөхрөлөөс мултрахын тулд бурхан тэнгэрт итгэх хэрэгтэй байж болох учраас би сайн үйл хийх ёстой. Бурхан тэнгэр аливааг удирдаж байгаа учраас юм сайн байгаа бус, дүрэм журам ёс суртахуунлаг, сайн учраас түүнийг бурхан тэнгэрээс илгээсэн гэж итгэж байна. Ийм учраас ёс зүй итгэл бишрэлийг буй болгодог. Кантын хэлснээр харин ёс зүй

нь шашныг дэлгэрүүлдэг. Гэхдээ шашин түүний дор харъяалагдахгүй ч ёс зүйг ердөө буруутгаад байдаггүй. Хэрэв бурхан тэнгэр оршин байхгүй байсан ч, үхсэний дараа юу ч болохгүй байсан ч хийх үүргээсээ, өөрөөр хэлбэл, энэрэнгүйгээр үйлдэхээс та чөлөөлөгдөхгүй.

“Хүн шиг авирлахаас өөр тийм сайхан, тийм зүйтэй юм үгүй” гэж Монтень бичжээ. Аливаа хүний үүрэг бол зөвхөн хүн байх, цорын ганц сайн үйлс бол хүн байх. Үүнийг таны өмнөөс хэн ч хийхгүй.

Энэ нь аз жаргалыг орлохгүй, тийм болохоор ёс зүй бол аливаа юм биш. Энэ нь хайрыг орлохгүй, тийм болохоор ёс зүй хамгийн чухал зүйл биш. Гэвч аз жаргал түүнийг шаардлагагүй болгодоггүй, хайр сэтгэл түүнийг оролдоггүй. Тэгэхлээр ёс суртахуунт байдал хэрэгтэй байдаг.

Энэ бол танд өөрөөрөө, чөлөөтэй байх (өөрийн зөн, өөрийн айдсын боол байснаас), бусдын дунд чөлөөтэй амьдрах боломжийг өгч буй явдал юм.

Ёс зүй бол танд аминчлан олгогдсон түгээмэл (дор хаяад бүх нийтийнх байх боломжтой) зайлшгүй шаардлага юм.

Сайн хүмүүсийн ачаар хүн төрөлхтөн оршин тогтнож байна. Танд хэрэгтэйн яг адил, түүнд та ч бас хэрэгтэй. Энэ бол зайлшгүй!

Тайлбар: Францын Сорбонны их сургуулийн философийн профессор Андре Комте-Спонвилле-гийн бүтээлүүд үүнээс өмнө дэлхийн 24 хэл дээр орчуулагджээ. Энд МУИС-ийн **профессор, доктор Т.Дорждагва, доктор Б.Гантөмөр** нар түүний 1988 онд бичсэн, 2007 оны ISBN-ийн бүртгэл бүхий “The Little Book of Philosophy” номын “Ethics” гэсэн бүлгийг англи хэлнээс орчуулсанаа эрхэм уншигчдын хүртээл болгож байна.